



СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.08.23 № А-1/3431
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЭЗХЯ/20240103131 дугаартай “Бүрэн-Зуунмод чиглэлийн 160км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төсөл /Төв/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

№	Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 заалтад “Ажлын даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, графикийг боловсруулахдаа 90 хоногт багтаан гүйцэтгэхээр төлөвлөсөн байх” гэсэн байна.</p> <p>Бидний олон жилийн туршлагаар ТЭЗҮ болон Инженерийн нарийвчилсан зураг төслийн ажил нь үе шаттай буюу нэг дор хийгддэггүй бөгөөд эхлээд ТЭЗҮ-гийн ажил хийгдэж, холбогдох байгууллагаар авто замын чиглэл батлагдсаны дараагаар инженерийн нарийвчилсан зураг төслийн ажил, бусад инженер геодези, инженер геологи гэх зэрэг ажлууд хийгддэг билээ.</p> <p>Энэхүү заалтаар 90 хоногт Зөвхөн ТЭЗҮ-гийн ажил хийгдэх боломжит хугацаа бөгөөд чиглэлээ баталгаажуулсны дараагаар гүйцэтгэх инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах хугацааг тодорхой тавьж өгөөгүй байна гэж ойлгож байна. Иймээс инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах хугацааг тодруулж өгнө үү.</p>	<p>Энэхүү төсөл, арга хэмжээний санхүүжилт нь 2024 онд бүрэн хийгдэх тул Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно” гэж заасны дагуу зураг төсөл боловсруулах хугацааг тухайн төсвийн жилд багтаан тусгахаар заасан. Иймд инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах хугацаа 90 хоног байна.</p>
2	<p>Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 заалтад: Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцөд геологийн инженер-1 гэж заасан байна.</p> <p>Авто замын ТЭЗҮ, Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах үйл ажиллагаанд “Геологийн инженер”-ийн оролцоо бага байдаг бөгөөд инженер геологийн суурь судалгааг мэргэжлийн байгууллагаар бид гүйцэтгүүлж дүгнэлт гаргуулдаг билээ. Харин гидрологийн инженер буюу ус зүйн инженерийн оролцоо маш их байдаг билээ.</p>	<p>Тус төсөл, арга хэмжээг гүйцэтгэхэд шаардлагатай инженер, техникийн ажилтныг тендерийн баримт бичигт заасан болно.</p>
3	<p>ТЭЗҮ-гийн ажлын даалгавар: Бүрэн-Зуунмод чиглэлийн 160 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ боловсруулах даалгаварт тус чиглэл нь “Орон нутгийн чанартай авто зам” гэж тусгайлан зааж өгсөн байна.</p> <p>Мөн 7-р зүйлд “ТЭЗҮ боловсруулах үе шат” гэсэн заалтад: ТЭЗҮ-гийн тайланг ЗТХЯ-ны Авто замын бодлого</p>	<p>Тухайн төсөл, арга хэмжээний ажлын даалгаварт техник, эдийн засгийн үндэслэлийн тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газарт хянуулахаар зааж ирүүлсэн</p>

1324029128

<p>зохицуулалтын газарт ирүүлж хянуулсны дараа, ЗТХТ ТӨҮГ-гийн дэргэдэх Авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар, дараа нь ЗТХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлж ЗТХЯ-нд ирүүлнэ... гэсэн байна.</p> <p>Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн "17.3. Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, түүний зурвас газрыг эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, түүнээс эрх олгосон этгээд байна." гэж заасан байдаг.</p> <p>Мөн "Бүрэн-Зуунмод чиглэлийн 160 км хатуу хучилттай авто зам"-ын ТЭЗҮ-гийн ажлын даалгавар, Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг Төв аймгийн Засаг дарга баталсан байхад Орон нутгийн чанартай авто замын асуудал хариуцаагүй ЗТХЯ-ны Авто замын газраар хянуулах, ЗТХТөвийн ШУТЗөвлөлөөр оруулах, ЗТХЯ-ны ШУТЗөвлөлөөр оруулах ажилбарууд орсныг тодруулж өгнө үү.</p>	<p>бөгөөд захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт өөрчлөлт оруулах эрх зүйн үндэслэл тус газарт байхгүй болно.</p>
---	---

ДАРГА



Ц.БАТЗУЛ